ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 09 өдөр Дугаар А/126 Мөрөн сум

“ Арьс ширний үйлдвэрийн хашаажуулалт цахилгаан хэрэгсэл”-ийн гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 24-ний өдрийн А/47 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 04 сарын 03-ний өдрийн 03 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1.Иргэн Э.Дашдаваа нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар “Арьс ширний үйлдвэрийн хашаажуулалт, цахилгаан хэрэгсэл” худалдан авах ажлын тендерт ялж 2025 оны 04 сарын 09-нд гэрээ байгуулсан тул уг ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Ш.Баасандорж	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Гишүүдэд:	С.Сүхчулуун	Зөөлөн багийн засаг дарга
	Ж.Алтанцэцэг	Татварын улсын байцаагч
	Г.Энхцэцэг	Бичиг хэргийн ажилтан
	А.Энхтөр	Нярав

2.Иргэн Э.Дашдаваагаас хүлээн авах “Арьс ширний үйлдвэрийн хашаажуулалт, цахилгаан хэрэгсэл”-ын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн тоо ширхэг, хүчин чадал, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Ш.Баасандорж) -д үүрэг болгосугай.

ДАРГА Н.НАМЖИЛНОРОВ

C:\My Documents\ ТУШААЛ .d